



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 44

Номгон

Аймгийн газар тариалангийн газрын бүсчлэлийг тогтоож, газар тариалангийн талбайд нэгдсэн тооллого хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Тариалангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн газар тариалангийн бүсчлэлийг нэгдүгээр, аймгийн газар тариалангийн талбайд нэгдсэн тооллого хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Газар тариалангийн талбайн нэгдсэн тооллого хийх ажлыг чанартай зохион байгуулж, шаардагдах төсөв хөрөнгийг зарцуулж, тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд 2017 оны эхний хагас жилд багтаан тайлагнахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

116759


Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 03 дугаар сарын 18-ны  
өдрийн 44 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



АЙМГИЙН ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БҮСЧЛЭЛ

д/д	Бүсийн дугаар	Хамрагдах сумдын нэр	Нийт ашиглагдах талбай /га/	Ашиглаж байгаа талбай /га/	Тариалах тарималын төрөл	Ургамал ургах хоногийн тоо	Жилд унах хур тунадас мм
1	2	3	4	5	6	7	8
1	1-р бүс Хангайн бүс	Жаргалант	812	119.3	Хадлан тэжээлийн ургамал, жимс, жимсгэнэ, эрт ургацын хүнсний ногоо	109-152	250 мм
2		Заг	231	59			
3		Галуут	140.2	87.8			
4		Хүрээмарал	9.7	6.5			
5		Баянбулаг	4.9				
6		Гурванбулаг	6.3	0.1			
1-р бүсийн дүн			1204.1	272.7			
7	2-р бүс Төвийн бүс	Эрдэнэцогт	73.3	25.52	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ болон бусад таримал	136-162	100-150 мм
8		Өлзийт	565	246			
9		Баян-овоо	89.5	72.62			
10		Баянхонгор	103.21	84.67			
11		Бөмбөгөр	220.7	82			
12		Бууцагаан	152	125.54			
13	Баацагаан	908	38.96				
2-р бүсийн дүн			2111.71	675.31			
14	3-р бүс Говийн бүс	Баянцагаан	170.7	73.2	Эмийн болон жимс, хүнсний ногооны үржүүлэг, тариалалт	182-218	50-100 мм
15		Жинст	7.5	7.5			
16		Богд	13.6	13.6			
17		Баянлиг	194	16.7			
18		Баянговь	97.4	17.19			
19		Шинэжинст сумын 1,4-р багийн нутаг бүтэн, 2,3-р багийн нутгийн хойт хэсэг	29	19			
20	Баян-Өндөр	5	5				
3-р бүсийн дүн			517.2	152.19			
	4-р бүс Говь цөлийн бүс	Алтайн өвөр говийн сав дагууд Баян-Өндөр, Шинэжинст, Баянговь, Баянлиг сумдын өмнөд хэсэг			Тариалан эрхлэх боломжгүй бүс нутаг		
Аймгийн нийт дүн			3825.51	1041.2			

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 03 дугаар сарын 18-ны  
өдрийн 44 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



АЙМГИЙН ГАЗАР ТАРИАЛАНГИЙН  
ТАЛБАЙД НЭГДСЭН ТООЛЛОГО ХИЙХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,  
хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Газар тариалан  
үйлдвэрлэл, технологи хариуцсан мэргэжилтэн, аймгийн ерөнхий агрономич

Гишүүд: Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газар  
зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын  
Геодезийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Сумдын Засаг дарга нар

Сумдын газрын даамал

Сумдын Мал эмнэлэг, үржлийн тасгийн Бэлчээр, газар тариалангийн  
асуудал хариуцсан мэргэжилтэн

Холбогдох багийн Засаг дарга нар